



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

“Гэр даатгал” ХХК-д дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21.3.2, 21.5, 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Гэр даатгал” ХХК-ийн дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээг 500,000,000 /таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараахь байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	А.Гансүх	850,500,000	250,000,000	1,100,500,000	55.025 хувь
2	“Вектор Интэрнэшнл” ХХК	649,500,000	250,000,000	899,500,000	44.975 хувь
	Дүн	1,500,000,000.0	500,000,000.0	2,000,000,000.0	100 хувь

2. Дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2013 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Гэр даатгал” ХХК /Г.Баттогтох/-д үүрэг болгосугай.

000081

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба
/Х.Бум-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



The stamp is a red square seal. It contains the Mongolian text 'МОНГОЛЫН ХУУЛЬЧИЙН ЯАМ' (Ministry of Justice of Mongolia) in the center, with 'ХТ' (Legal Department) below it. The words 'МОНГОЛ' (Mongolia) and 'ЯАМ' (Ministry) are written vertically on the left and right sides of the seal respectively.